

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 2 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Барилга, хот байгуулалтын хэлтэс:

Барилгын хөгжлийн төвөөс 2024 онд хамтран хэрэгжүүлэх ажлын гэрээ байгуулах, 2023 оны гэрээ дүгнэх, санал солилцох, зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уулзалтад аймгийн Ерөнхий архитектор, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга болон хэлтсийн дарга нар оролцлоо.

Зөвлөлдөх уулзалтаар:

- Орон нутагт нийтийн орон сууцны төсөл хөтөлбөрүүдийг дэмжих
- Түрээсийн орон сууцны хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлэх
- Зураг төсөвгүй ажлууд орон нутагт хэрэгжүүлэхгүй байх
- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй аймгууд хийлгэх, хийлгэсэн аймгууд шинэчлэх, сайжруулах, мөрдөж ажиллах тал дээр онцгой анхаарч ажиллах чиглэлийг Барилга, хот байгуулалтын яамнаас аймгуудад өгсөн.



Газрын удирдлагын хэлтэс

- Монгол улсын ерөнхий сайдын 2024 оны 04 дүгээр захирамжаар Монгол улсын Газрын нэгдмэл сан, газар эзэмшил, ашиглалт, бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх үүрэг чиглэл өгсний дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны А/17 дугаар тоот тушаалаар улсын хэмжээнд ажлын хэсэг гарч аймаг бүрээс 1-2 сумын газрын харилцааны цахим болон цаасан суурьтай баримт материалуудад үзлэг шалгалт хийгдэж байна.

Манай аймгийн хэмжээнд Шивээговь сумын газрын харилцааны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэхээр батлагдсаны дагуу 2003-2023 он хүртэлх холбогдох судалгаа мэдээллийг сумтай хамтран гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлээд байна.

- Аймгийн орон нутгийн төсвөөр 2024 онд Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын 74 сая төгрөг, Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах 93.2 сая төгрөг тус тус батлагдсан.

Дээрх ажлуудын худалдан авалтын сонгон шалгаруулалтыг зарлуулахаар ажлын даалгаврыг аймгийн Засаг дарга болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын дарга нараар батлуулан аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлээд байна.

- ОХУ-аас БНХАУ руу манай улсын газар нутгаар дайран өнгөрөх байгалийн хийн хоолойн зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажилтай холбогдуулан аймгийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 2024 оны 09 дүгээр тогтоолоор баталсныг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.